ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/149/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>Мөрөн сум<br>2022 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ<br>Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br>Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн<br>Ерөнхий захирал: Т.Батсайхан<br>Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com<br>Аудитын менежер: Г.Оюунгэрэл<br>Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....................................................................................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........................................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..........................................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......................................................4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................................6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан...............................................................7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .........................................................8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..............................................9
3. Аудитын тайлан....................................................................................................10
3.1 Ерөнхий зүйл .........................................................................................................10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ......................................................10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ...........................................................11
3.4 Материаллаг байдал ..............................................................................................11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................................................11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......................................................13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .............................................13
3.8 Аудитын гол асуудал..............................................................................................14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..............14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..............................................................14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................................................................14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...............................................................14
4. Аудитын илрүүлэлт ................................................................................................14
4.1 Залруулсан алдаа .................................................................................................. 14
4.2 Төлбөрийн акт ........................................................................................................ 14
4.3 Албан шаардлага .................................................................................................... 14
4.4 Зөвлөмж.................................................................................................................. 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ...........................................................16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/188
танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Т.АНХЖАРГАЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,417,994.28** | **217,095,138.32** |
| **33** | **АВЛАГА** | **500,000.00** | **105,783,000.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 105,783,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **36,917,994.28** | **111,312,138.32** |
| **351** | **Түүхий эд материал** | **12,373,770.28** | **78,723,774.32** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,173,148.00 | 19,335,475.40 |
| 35130 | Эм боох материал | 8,200,622.28 | 59,388,298.92 |
| **354** | **Хангамжийн материал** | **24,544,224.00** | **32,588,364.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 195,000.00 | 195,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,800.00 | 583,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,511,400.00 | 5,916,600.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 8,400.00 | 8,400.00 |
| 35460 | Хүнсний материал | 42,500.00 | 3,025,240.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,760,124.00 | 22,860,124.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **300,941,099.95** | **302,871,173.63** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **300,941,099.95** | **302,871,173.63** |
| **392** | **Биет хөрөнгө** | **269,465,099.95** | **286,395,173.63** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 216,015,094.58 | 216,015,094.58 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -42,508,431.84 | -63,762,647.93 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 80,620,000.00 | 72,870,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -25,699,444.14 | -30,094,444.10 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 116,576,049.80 | 115,465,740.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -90,291,378.11 | -39,890,548.31 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,834,460.00 | 11,020,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3,584,949.19 | -3,406,030.82 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 20,666,393.70 | 20,666,393.70 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -12,162,694.85 | -12,488,383.85 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **31,476,000.00** | **16,476,000.00** |
| 39301 | Програм хангамж | 15,781,470.00 | 781,470.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -781,470.00 | -781,470.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,476,000.00 | 16,476,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **338,359,094.23** | **519,966,311.95** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **338,359,094.23** | **519,966,311.95** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **338,359,094.23** | **519,966,311.95** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 416,783,360.00 | 416,783,360.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 416,783,360.00 | 416,783,360.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-246,834,522.53** | **-65,227,304.81** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -246,834,522.53 | -246,834,522.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 181,607,217.72 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 168,410,256.76 | 168,410,256.76 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **338,359,094.23** | **519,966,311.95** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **485,840,735.02** | **1,018,549,933.34** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **73,590,346.02** | **306,701,558.34** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **73,590,346.02** | **306,701,558.34** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 73,590,346.02 | 306,701,558.34 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 73,590,346.02 | 306,701,558.34 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **54,281,589.00** | **711,848,375.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 357,968,800.00 | 401,618,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **7,762,400.00** | **264,370,165.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,565,600.00 | 158,587,165.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 196,800.00 | 105,783,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **19,760,000.00** | **21,260,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,760,000.00 | 21,260,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **26,759,189.00** | **24,599,410.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 26,759,189.00 | 24,599,410.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **465,900,841.54** | **821,942,715.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **465,900,841.54** | **821,942,715.62** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **465,900,841.54** | **792,542,715.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **300,049,071.62** | **368,305,500.00** |
| 210101 | Үндсэн цалин | 300,049,071.62 | 194,036,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 108,668,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 5,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 41,132,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 18,708,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,170,028.38** | **48,466,204.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,955,619.30 | 34,105,336.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,053,602.27 | 3,598,302.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,442,881.82 | 2,878,641.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 610,720.45 | 711,885.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,107,204.54 | 7,172,040.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **6,502,746.00** | **17,354,800.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,085,466.00 | 2,499,729.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,857,280.00 | 14,295,071.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 560,000.00 | 560,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **34,185,014.00** | **30,935,265.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,745,000.00 | 1,993,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,679,254.00 | 21,138,665.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,570,000.00 | 2,790,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 64,000.00 | 200,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 470,200.00 | 1,252,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,359,180.00 | 3,560,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **35,966,036.42** | **266,964,006.74** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,890,896.42 | 254,195,474.74 |
| 210502 | Хоол, хүнс | 5,075,140.00 | 12,768,532.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,003,360.00** | **5,500,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 4,003,360.00 | 5,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **852,000.00** | **928,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 852,000.00 | 928,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,644,200.00** | **3,326,256.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 221,600.00 | 1,081,496.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 850,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 60,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,000.00 | 50,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 34,200.00 | 164,760.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 858,400.00 | 1,100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **44,528,385.12** | **50,762,683.88** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,862,000.00 | 5,870,450.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40,666,385.12 | 44,892,233.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **00.00** | **29,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **00.00** | **29,400,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 29,400,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **19,939,893.49** | **196,607,217.72** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **00.00** | **15,000,000.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 15,000,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **00.00** | **-15,000,000.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **19,939,893.49** | **181,607,217.72** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **C01** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **400,307,360.00** | **-145,831,231.87** | **265,512,670.83** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 2,944,200.00 | 2,944,200.00 |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **400,307,360.00** | **-142,887,031.87** | **268,456,870.83** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | -2,944,200.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -11,137,091.30 | -11,137,091.30 |
| **C08** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **416,783,360.00** | **-246,834,522.53** | **338,359,094.23** |
| **D01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **416,783,360.00** | **-246,834,522.53** | **338,359,094.23** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **416,783,360.00** | **-246,834,522.53** | **338,359,094.23** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 181,607,217.72 | 181,607,217.72 |
| **D09** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **416,783,360.00** | **-65,227,304.81** | **519,966,311.95** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **412,250,389.00** | **606,065,375.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **412,250,389.00** | **606,065,375.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 357,968,800.00 | 401,618,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **7,762,400.00** | **158,587,165.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,565,600.00 | 158,587,165.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **19,760,000.00** | **21,260,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,760,000.00 | 21,260,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **26,759,189.00** | **24,599,410.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 26,759,189.00 | 24,599,410.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **410,750,389.00** | **599,945,375.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **410,750,389.00** | **599,945,375.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **410,250,389.00** | **570,545,375.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **278,592,800.00** | **368,305,500.00** |
| 210101 | Үндсэн цалин | 172,766,300.00 | 194,036,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 85,306,500.00 | 108,668,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,520,000.00 | 5,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 15,000,000.00 | 41,132,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 18,708,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **36,901,500.00** | **48,466,204.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,934,500.00 | 33,913,004.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,719,400.00 | 4,076,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,175,500.00 | 2,646,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 633,300.00 | 938,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,438,800.00 | 6,892,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,760,000.00** | **17,760,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,085,466.00 | 2,499,729.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,114,534.00 | 14,700,271.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 560,000.00 | 560,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **26,448,400.00** | **35,019,365.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,500,000.00 | 1,993,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,178,400.00 | 21,138,665.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,570,000.00 | 2,790,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 200,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 2,465,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 6,431,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **18,875,689.00** | **84,589,600.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,545,489.00 | 69,243,028.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,330,200.00 | 15,346,572.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,330,000.00** | **6,280,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 330,000.00 | 780,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 5,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **852,000.00** | **928,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 852,000.00 | 928,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **24,509,000.00** | **3,326,256.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,944,800.00 | 1,081,496.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 850,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 60,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,000.00 | 50,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 34,200.00 | 164,760.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,000,000.00 | 1,100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,981,000.00** | **5,870,450.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,981,000.00 | 5,870,450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **500,000.00** | **29,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **00.00** | **29,400,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 29,400,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,500,000.00** | **6,120,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,500,000.00** | **6,120,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,500,000.00** | **6,120,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,500,000.00** | **6,120,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,500,000.00 | 6,120,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1,500,000.00** | **-6,120,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 449,525,000.0 | 447,478,210.0 | 2,046,790.0 | -00.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 449,525,000.0 | 447,478,210.0 | 2,046,790.0 | -00.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 449,525,000.0 | 447,478,210.0 | 2,046,790.0 | -00.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 324,114,900.0 | 324,114,900.0 | 00.0 | 00.0 |
| 210101 | Үндсэн цалин | 175,119,600.0 | 175,119,600.0 | 00.0 | 00.0 |
| 210102 | Нэмэгдэл | 107,306,800.0 | 107,306,800.0 | 00.0 | 00.0 |
| 210104 | Урамшуулал | 17,220,000.0 | 17,220,000.0 | 00.0 | 00.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,755,600.0 | 43,755,600.0 | 00.0 | 00.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,791,000.0 | 30,791,000.0 | 00.0 | 00.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,241,100.0 | 3,241,100.0 | 00.0 | 00.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,593,000.0 | 2,593,000.0 | 00.0 | 00.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 648,200.0 | 648,200.0 | 00.0 | 00.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,482,300.0 | 6,482,300.0 | 00.0 | 00.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,760,000.0 | 17,760,000.0 | 00.0 | 00.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,000,000.0 | 2,499,729.0 | 500,271.0 | -16.7 |
| 210302 | Түлш, халаалт | 14,200,000.0 | 14,700,271.0 | -500,271.0 | 03.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 560,000.0 | 560,000.0 | 00.0 | 00.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,785,900.0 | 25,785,900.0 | 00.0 | 00.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,993,400.0 | 1,993,400.0 | 00.0 | 00.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,242,500.0 | 17,242,500.0 | 00.0 | 00.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,750,000.0 | 2,750,000.0 | 00.0 | 00.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.0 | 200,000.0 | 00.0 | 00.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.0 | 1,800,000.0 | 00.0 | 00.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,800,000.0 | 1,800,000.0 | 00.0 | 00.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,267,600.0 | 21,267,600.0 | 00.0 | 00.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 15,067,600.0 | 15,067,600.0 | 00.0 | 00.0 |
| 210502 | Хоол, хүнс | 6,200,000.0 | 6,200,000.0 | 00.0 | 00.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,500,000.0 | 6,500,000.0 | 00.0 | 00.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.0 | 3,000,000.0 | 00.0 | 00.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,500,000.0 | 3,500,000.0 | 00.0 | 00.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,000,000.0 | 856,000.0 | 144,000.0 | -14.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.0 | 856,000.0 | 144,000.0 | -14.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,260,000.0 | 2,244,760.0 | 15,240.0 | -00.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 850,000.0 | 850,000.0 | 00.0 | 00.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,081,000.0 | 5,193,450.0 | 1,887,550.0 | -26.7 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 449,525,000.0 | 447,478,210.0 | 2,046,790.0 | -00.5 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 401,618,800.0 | 401,618,800.0 | 00.0 | 00.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 401,618,800.0 | 401,618,800.0 | 00.0 | 00.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 21,260,000.0 | 21,260,000.0 | 00.0 | 00.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 21,260,000.0 | 21,260,000.0 | 00.0 | 00.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24.00 | 24.00 | 00.00 | 00.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 00.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 | 00.00 | 00.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 | 00.00 | 00.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **158,587,165.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **158,587,165.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **129,187,165.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,233,465.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,896,165.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 40,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,081,496.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,081,496.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 158,587,165.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 158,587,165.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 158,587,165.00 |

| | | |
|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой асуудалд албан шаардлага өгч тайланд тусгасан.

Аудитыг Захирал Т.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 235 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/А/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж,

үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай

- "Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан" 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- "Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж" 2021 оны А243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. "Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн томилох тухай 2021 оны 11 сарын 09 өдрийн А/4 тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчилж 10 чиглэлээр ажлын төлөвлөгөөг баталжээ.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 812.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 181.6 сая төгрөгөөр буюу 53.7 хувиар өссөн

байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулав.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0.5 | 105.7 | 105.2 |
| Бараа материал | 36.9 | 111.3 | 74.4 |
| Биет хөрөнгө | 269.4 | 286.3 | 16.9 |
| Биет бус хөрөнгө | 31.4 | 16.4 | -15.0 |
| **Нийт хөрөнгө** | **338.3** | **519.9** | **181.6** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **338.3** | 519.9 | 181.6 |

Авлагын үлдэгдэл 105.7 сая төгрөг байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлага. Энэ авлагын тооцоог нийлж баталгаажуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 74.4 сая төгрөгөөр өсөж 111.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан эм боох материал 66.4 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн авсан вакцин, эм тариа 209.2 сая төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан түлш шатах тослох материал 35.8 сая төгрөг,
- Хүнсний материал 15.7 сая төгрөг,
- Бусад хангамжийн материал 63.4 сая төгрөг,

Тайлант хугацаанд нийт 316.1 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.
Иргэний хандиваар 0.5 сая төгрөгийн аж ахуйн материал, хүнс авсан.

Биет хөрөнгийн үлдэгдэл 16.9 сая төгрөгөөр өсөж 286.3 сая төгрөг болсон. Үүнд материаллаг нөлөөтэй биет хөрөнгө:

- Иргэний хандиваар авсан хүчилтөрөгчийн аппарат 3.6 сая төгрөг,
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 01-ний өдрийн А/741 тоот тушаалаар “МонПэн” төслийн хүрээнд тавилга, хэрэгсэл, компьютер техник хэрэгсэл 4.0 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А/71 тушаалаар хог хаягдлын автоклав 9.7 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А/90 тушаалаар зөөврийн технологи 16.7 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 11сарын 15 А/16 тушаалаар лабораторийн тоног төхөөрөмж 14.2 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 сарын 7-ны өдрийн А/148 -р тушаалаар дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж 4.7 сая төгрөг,
- Тайлант хугацаанд Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 21-ний өдрийн 109-р тогтоолоор 51.6 сая төгрөг, Цагаан-Үүр сумын ИТХ-ын 2021 оны 12 сарын 18-ны өдрийн 40-р тогтоолоор 18.7 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, нийт 69.4 сая төгрөгийг биет хөрөнгө данснаас хассан.

Биет бус хөрөнгө нь 14.0 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 118 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 28 дугаар тогтоолоор 15.0 сая төгрөгийн өртөгтэй “Цахим эрүүл мэнд” программыг акталсантай холбоотой байна.Энэ аймгийн олон ЭМТ-д 2012 онд өндөр үнэтэй “Цахим эрүүл мэнд” программ хангамж авч түүнээс хойш ашиглаагүй учир элэгдэл байгуулалгүй хадгалж байгаад одоо анхны өртөг 15.0 сая төгрөгөөр данснаас хасаж алдагдал үүсгэсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 615.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 615.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсөв захирагч 2021 оны төсвийн төслийг бууруулан 449.5 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 401.6 сая төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 21.3 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 26.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийг нийт 447.6 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагад дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 158.5 сая төгрөг хуваарилснаас Эрүүл мэндийн даатгалын сангаас 128.0 сая, ЭМЯ-аас 29.4 сая төгрөгийг тус тус хуваарилсан.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 44.1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 4.7 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 9.2 сая төгрөг, норматив зардалд 63.3 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 5.9 сая төгрөг, дотоод албан томилолтод 0.07 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 1.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.6 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 29.4 сая төгрөг нийт 158.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Нэмэлт төсвөөс 105.7 сая төгрөгийн авлагатай, тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал, үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Ковидын тархалттай холбогдсон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 358 хүн өвчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 3719 тун вакцинд иргэдийг хамруулж нийт 233.7 сая төгрөг нэхэмжилснээс 128.0 сая төгрөгийн санхүүжилт авч 105.7 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан

нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 872.8 сая төгрөгийн 46 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 833.2 сая төгрөгийн 41 мэдээллийг ил тод байршуулж 39.6 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, дахин давтахгүй байх албан шаардлага өгөв..

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайланд Ихэр мөрөн аудит ХХК аудит хийж 4 зөвлөмж хүргүүлсний 3 зөвлөмж бүрэн биелж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дутуу байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчилсөн байх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.1 сая төгрөгийн нийт 2 алдаа илрүүлж, 14.1 сая төгрөгийн 1 залруулга, 1 албан шаардлага өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 14.1 сая төгрөгийн Нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

1. **Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой асуудал**

Ихэр мөрөн аудит ХХК нь Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төв нь 2020 оны аудитаар шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтэд зөвлөмж өгсөн байна. 2021 оны аудитаар дахин шилэн дансны мэдээлэлд 5 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна.

Энэ нь “Шилэн дансны тухай хууль” хуулийн 6-р зүйлийн 6.1 хэсэгт заасныг зөрчсөн байна. Иймд Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд оруулж дахин давтахгүй байх шаардлага өгөв.

## 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төв | 2 | 14.1 | 1 | 14.1 | - | - | 1 | - | - | - |